

Уул уурхайн жишиг сургууль Говьсүмбэр аймаг дахь

Политехник коллеж



**СЭДЭВ: БАГШ ХӨГЖЛИЙН ТӨВ
БАЙГУУЛЖ БАГШИЙГ АЖЛЫН
БАЙРАНД ҮР ДҮНТЭЙ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**

**АВХҮҮ ЧУЛУУНЧИМЭГ
БААТАР МӨНХБАЯСТАЛАН**

2019 он

**Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй
хөгжүүлэх нь**

Агуулга

Оршил хэсэг

1. Удиртгал.
2. Үндэслэл
3. Судалгааны зорилго
4. Судалгааны зорилт
5. Судалгааны аргууд

1. Нэгдүгээр бүлэг

1.1. Багшийн хөгжил гэж юу вэ?

1.2. Зарим их дээд сургууль болон гадны улс орнуудын багш хөгжлийн төвийн сайн туршлагууд

1.3. Багшийн хөгжилд тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд

2. Хоёрдугаар бүлэг

2.1. Ерөнхий боловсролын сургуулиудын багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг судалсан судалгаа

2.2. Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулсанаар багшийн хөгжилд гарах эерэг үзүүлэлтүүдийг судалсан судалгаа

2.3. Жишиг багш хөгжлийн төв байгуулж өөрийн сургуулийн багш нараа ажлын байрандаа үр дүнтэй хөгжих боломжийг эрэлхийлсэн судалгаа

2.4. Багш хөгжлийн төвийг байгуулан өөрийн сургуулийн багш нарын зөвлөлтэй хамтран хэрхэн үр дүнтэй ажиллах шийдэл гаргалгаа

2.5. Жишиг багш хөгжлийн төвийн зураглал, багш хөгжлийн загвар төлөвлөгөө

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Оршил

Хувь хүний хөгжлөөс эх орны хөгжил хамаардаг болсон өнөө үед боловсролын гол хөдөлгөгч хүч болсон багшийн хөгжлийн тухай асуудал манай улс төдийгүй дэлхий нийтийн нэн тэргүүнд тавигдаж байгаа асуудал болоод байна. Тиймээс төр засгаас багшийн хөгжлийг дэмжих бодлого баримталж олон үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг шат шатанд хэрэгжүүлж байна. Мэргэжлийн боловсролын салбарын хувьд мөн багш нарын хөгжлийн хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд суурилсан, үйлдвэрлэлийн хэрэгцээгээр удирдуулсан, төгсөгчийн мэргэжлийн үр чадвар, ажлын байраар баталгаажсан мэргэжилтэй ажилтан бэлтгэх шинэ тогтолцооны хөтлөгч хүч болж, суралцагч бүрийнхээ сонирхол, эрмэлзэл, авъяас чадварыг танин мэдэж, түүнд нийцүүлэн сурах аргаа сонгодог, мэргэжлийн мэдлэг, чадвар, заах арга зүйгээ тасралтгүй дээшлүүлдэг, өрсөлдөх чадвартай мэргэжилтэй ажилтан сургаж чадахуйц багшийг бэлтгэх, төлөвшүүлэх, хөгжүүлэх¹ зорилготойгоор ажиллаж байгаа билээ. Багшийн хамгийн их цагаа өнгөрүүлдэг ажлын байранд нь багшийг хөгжих нөхцөл боломжоор хангаж өгөх нь сургалтын байгууллагын нэг чухал үүрэг юм.

¹ Монгол улсын хөдөлмөрийн сайдын 2015 оны А/214 дүгээр тушаалаар Мэргэжлийн боловсрол сургалтын багшийн хөгжлийн хөтөлбөрийг батлан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Үндэслэл :

Өөрийн сургуулийн багш нарын ажлын байрандаа тасралтгүй хөгжих хэрэгцээ шаардлагыг нээн илрүүлэх улмаар сургуулийн онцлог давуу тал болон материаллаг бааз, орчин нөхцөл, залуу багш нарынхаа хөгжих хүсэл эрмэлзлэлд тулгуурлан хамтдаа хөгжих, харилцан бие биенээсээ суралцах таатай орчин бүрдүүлж заах арга зүй, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх манай сургуулийн багш нарын нэн тэргүүний асуудал. Аливаа сургуулийн хүчирхэг биеэ даасан байдал хөгжсөн багш мэргэшсэн багшаас шууд хамааралтай

Судалгааны ажлын зорилго:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго ², монгол улсын уул уурхайн жишиг сургууль политехник коллежийн 2018-2019 оны хичээлийн жилийн зорилгыг³ хэрэгжүүлэх, багш нарын тасралтгүй хөгжихөд тулгамдаж буй асуудлуудыг цогц байдлаар шийдэх боломжийг эрэлхийлэх, багш хөгжлийн төв байгуулснаар багшийг ажлын байранд нь тасралтгүй хөгжүүлэх боломж бүрдэх эсэхийг судлах, бусад сургуулиудын багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа, орчин нөхцөл, үр дүнг тодорхойлж өөрийн сургуульд жишиг багш хөгжлийн төв байгуулах загвар зураглал болон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

Судалгааны ажлын зорилтууд:

- Дотоод болон гадаадын багш хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаа орчин нөхцлийг судлах
- Багшийн хөгжилд тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг нээн илрүүлж шийдвэрлэх арга замыг олох
- Жишиг багш хөгжлийн төвийн загвар зураглал хийх
- Багш хөгжлийн төвийн төлөвлөгөө гаргах

Судалгааны аргууд

- Судалгааны явцад ажиглалт хийх
- Харьцуулалтын дүгнэх
- Анкет асуулгын арга
- Нэгтгэн дүгнэх

² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.

³ Сургалтын чанар, сахилга хариуцлагыг дээшлүүлж суралцагчдыг бүтээлчээр хөгжүүлэх

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

1. Нэгдүгээр бүлэг

1.1 Багшийн хөгжил ба багшийн хөгжлийн менежмент

Мэдээлэл технологийн болон даяарчлалын зуунд шилжин орж байгаа өнөө үед дэлхийн түвшний боловсрол эзэмшсэн мэдлэг чадвар хандлагатай иргэнийг бэлтгэхэд багш хүний үүрэг, хариуцлага их юм. Өндөр боловсролтой, орчин цагтайгаа хөл нийлүүлэн байнга өсөж хөгжиж байдаг "Улсын", дэлхийн "иргэнийг бэлдэж буй багш хүн өөрөө ямар түвшний, ямар шалгуурт тэнцсэн, ямар зорилго хандлагатай, ямар төлөвшилтэй бие хүн байх вэ гэвэл:

- Хандлага зөв байх
- Хариуцлагатай байх
- Хөгжсөн байх нь зүй ёсны хэрэг юм.

Иймээс багшийн хөгжил бол боловсролын салбарын болон сургуулийн өөрчлөлт шинэчлэлийн үндэс, улс орны хөгжлийн суурь юм. Боловсролын хөгжлийн шинэ үзэл баримтлалаар багш хүн судлаач, оюун ухааныг дасгалжуулагч, эзэмшихүйн үе шатуудыг оновчтой зөв зохион байгуулагч, хөгжилд хөтлөгч байдаг. Тийм ч учраас багш хүн цаг ямагт хөгжиж цаг үетэй хөл нийлүүлэн алхах нь нэн түрүүнд тавигдах асуудал мөн юм, Багш нар сайн боловсрол эзэмшиж, хөгжсөнөөр боловсролын зөв хөгжил явагдах нь дамжиггүй юм, Учир нь багш бол боловсролын салбарын хамгийн чухал хэсэг юм. Багшийн чанар сайжрах тусам боловсролын чанар сайжирна. Боловсрол улс орныг өндөрт өргөнө. Үнэндээ сурагчид боловсрол мэдлэг эзэмшиж байгаа нь үнэн чанартаа улс орон боловсрол эзэмшиж байгаа хэрэг юм. Сайн боловсрол нь сайн боловсорсон, хөгжсөн багш нараас бий болдог. Сургуулийн хөгжлийг багшийн хөгжлөөр үнэлдэг гэж би боддог. Хөгжсөн багшаас хөгжсөн сурагч төрдөг учраас багш хүн тасралтгүй байнга хөгжиж байх нь өнөөгийн нэн тэргүүнд тавигддаг тулгамдаж буй асуудал юм.

Улсын хөгжил хүнээсээ, хүний хөгжил хүүхдээсээ, хүүхдийн хөгжил багшаасаа.

Тиймээс багш бидний өмнө маш их үүрэг хариуцлага оногдож байна. Гэвч багш, сурган хүмүүжүүлэгч бидэнд нэг талаар хариуцлага хүлээлгэж байгаа ч түүгээрээ дамжуулан өөрсдөөрөө бахархах боломжийг олгож байгаа юм шиг. Багш хүн хөгжил, өөрчлөлтийг цаг тухайд нь соргоогоор мэдэрч хөгжиж байх шаардлагатай. Багш хүн өөрөө харилцааны соёлтой, зөв боловсон зан үйлтэй, хайраар дүүрэн зүрх сэтгэлтэй, бусдад зөв үлгэр дуурайлал үзүүлж чадахуйц байх шаардлагатай юм. Сүүлийн үед манай улсын боловсролын чиг хандлага мэдлэг дамжуулах бус чадамжид суурилан хөгжиж байна. Иргэн хүний боловсрол нь чанартай, бүтээх чадавх нь тасралтгүй дээшилж байгаа улс орнууд өөрийн уламжлал, ёс заншлаа хадгалж, өрсөлдөх чадвар сайтай, өндөр хөгжилтэй байдаг.

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Багшийн хөгжлийг менежмент талаас нь авч үзвэл:

1. Багш өөрийгөө хөгжүүлэх хариуцлага, санаачлага, идэвх зүтгэл, сахилга бат
2. Багшийг хөгжүүлэх нэгдмэл бодлого, чиглүүлэх менежрийн туслалцаа, дэмжлэг
3. Багш бүрийн өөрийгөө хөгжүүлэх сонирхол, зорилтдоо захирагдах ёс зүй
4. Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо (цалин хөлс, ур чадварын урамшуулал, мэргэжил, мэргэшлийг нь дээшлүүлэх болзол г.м)
5. Багшийн хөгжлийн цогц бодлого
6. Багшийн ажлын байран дахь мэргэжлийн онол, заах ур чадвар, хамтын бүтээлч ажиллагааны өсөлт, хөгжил гэх мэт юм.

Өнөөдөр багшийн хөгжил ихэвчлэн гадны хүчин зүйлээс хамааралтай болж, зайлшгүй хөгжих “бэрхшээл” үүсдэггүй эсвэл тэрхүү “бэрхшээл”-ийг мэдрэхгүй байх.

“Та сургалтанд оролц”, “Та унших хэрэгтэй”, “Та хөгжихгүй бол болохгүй”. “Таны заах арга хоцрогдсон байна” гэсэн хөндлөнгийн шахалт, шаардлага аяндаа тавигдахад хүрч байна. Энэ нь багшийн үйл ажиллагааг хөндлөнгөөс, дээрээс нь үнэлж багшийг хөгжүүлэх гэдэг оролдлогын нөлөө ч байж мэднэ. **Багшийн үйл ажиллагаа нь элдэв бичиг баримт бүрдүүлэн дээрээс ирэх шалгалтанд үзүүлэх, удирдлагадаа бүртгүүлэх зэрэгт илүүтэй чиглэх болж суралцах үйлэнд хандсан бүтээлч өөриймсөг хандлага багасаж байгаа юм биш биз гэсэн эргэлзээ ч төрж байна.** Багш хүн өөрийн үйл ажиллагаандаа өөрөө дүн шинжилгээ хийж, суралцах үйлийг хамтран явуулж чадвал алдаа, оноо, амжилт бүтээлийнхээ мөн чанарыг ухааран мэдэх боломж бүрдэж энэ нь өөрийгөө хөгжүүлэх гол хүчин зүйл болох юм.

Суралцах үйлийн гол утга нь сургахад бус харин сурах үйлийг сурагчидтайгаа хамтран явуулж “багш, сурагч хоёр хичээл рүү хамтдаа” гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байгаа бөгөөд ингэсэн нөхцөлд багшийн тасаралтгүй хөгжих, суралцах хэрэгцээ үүснэ.

Боловсролын шинэчлэл бол багшийн сэтгэлгээний шинэчлэл юм.

Сэтгэлгээг гаднаас удирдан шинэчлэх гэсэн оролдлогоор үр дүнд хүрэх боломж тун эргэлзээтэй. Багш бүрийн өөрийгөө мэдрэх, нээн илрүүлэх идэвхтэй оролцоо л боловсролын шинэчлэлийн гол хүчин зүйл болно.

1.2 Зарим их дээд сургууль болон гадны улс орнуудын багш хөгжлийн төвийн сайн туршлагууд

Би энэхүү илтгэлээ бичихийн тулд дотоод болон гадаадын их дээд сургууль Тухайлбал: ШУТИС, АШУУИС, Хууль сахиулахын их сургуулийн багш хөгжлийн төвүүд мөн Даллас дахь Техасын их сургууль, Чикаго хотын их сургуулийн багш

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

хөгжлийн төв болон өөрийн аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд болох 1, 2, 5-р сургуулиудын багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа орчин нөхцлийг судалсан..

ШУТИС-ийн багш хөгжлийн төв

ШУТИС-ийн БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ нь багшийн тогтвортой хөгжлийг хангах, мэдлэг боловсролыг олон улсын түвшинд хүргэх, тасралтгүйгээр бие даан хөгжих нөхцлийг бүрдүүлэх, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох, гүйцэтгэлийн соёл өндөртэй багшлах залгамж халааг дэмжин чадавхжуулах зорилгоор 2015 оны 11-р сард Ректорын А/238 тоот тушаалаар байгуулагдсан бөгөөд багш хөгжлийн төвөөрөө дамжуулан багш нарынхаа хөгжил дэвшлийг сайжруулах, багшийн төлөвшил, ёс суртахуун, хариуцлага, эрдэм мэдлэг, сурган заах арга зүйн болоод бусад чадваруудыг хөгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх олон ажил зохион байгуулдаг юм байна. Тухайлбал :

- “Сургах-Суралцахуйн” арга зүйн сургалт, семинар, уулзалт-ярилцлага
- Харилцан туршлага солилцох

БХТ-ийн зөвлөх багш нар, бүрэлдэхүүн сургуулийн тэнхим, профессорын баг, заах арга зүйн зөвлөлүүдтэй хамтран:


- Ямар сургалтын аргууд таны хичээлд илүү таарах,
- Яаж оюутны сурах хэрэгцээг хангах,
- Хэлний болон бусад сургалтуудыг хэрхэн зохиох талаар хэлэлцүүлэг зэрэг ажлуудыг явуулдаг юм байна.

•
•



Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

МЭДЭЭ, ЗАРЛАЛ



АШУУИС-ийн Багшийн хөгжлийн төв

АШУУИС-ийн багш нарын тасралтгүй хөгжих үйл ажиллагааг дэмжих, боловсролын судалгааны арга зүй эзэмшүүлэх, сурган заах арга зүйн орчин үеийн ойлголт, мэдлэгийг амьдралд хэрэгжүүлж, үр дүнг тооцох, багш мэргэжлээрээ бахархах, үнэ цэнийг мэдрүүлэх зорилготойгоор Сургалтын Бодлого Зохицуулалтын Газрын дэргэд "Багшийн хөгжлийн төв" 2014 оны 10-р сарын 6-ны өдөр байгуулагдсан. Багшийн хөгжлийн төв нь судалгааны их сургууль болох АШУУИС-ийн зорилтод түлхэц үзүүлэх зорилгоор анагаах ухааны боловсрол судлалын хөгжил, дэвшлийг сургалтаар дамжуулан сайжруулах, судалгаа хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус төв нь гадаадын болон дотоодын их дээд сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд багш солилцоог дэмжин, багш нарыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулдаг. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлсэнээр харилцан туршлага солилцох, төвийн ирээдүйн төлөвлөгөөг гаргахад түлхэц үзүүлдэг. Мөн дотоод нөөц бололцоогоо түшиглэн сурган заах арга зүйн чиглэлийн сургалтуудыг тогтмол явуулдаг байна. Багш хөгжлийн төвөөрөө дамжин багш нар нь хэрхэн үр дүнтэй хөгжиж мэдлэг чадвараа дээшлүүлж буйгаа ярьж байна. <https://www.mnums.edu.mn/academics.php?category=bagsh&post=53&lang=mn>

Даллас дахь Техасын их сургуулийн Багш хөгжлийн төв /Teacher development center/



Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Чикаго хотын их сургуулийн багш хөгжлийн төв




Эдгээр сургуулиудын багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа ижил төстэй байдал, үр дүн нь :

- Арга зүйн хувьд шинэчлэл хийгддэг
- Оюутан суралцагчдаа төлөвшүүлэх хөгжүүлэхэд шаардлагатай сургалт судалгаа
- Багаар ажиллаж нэгдсэн нэг шийдэлд хүрдэг
- Бусад гадны болон дотоодын сургуулиудаас туршлага судалдаг
- Дотоод нөөц бололцоогоо түшиглэн хөгжих, харилцан суралцдаг зэрэг эерэг үр дүн гардаг нь харагдаж байна.

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Манай аймгийн Ерөнхий боловсролын сургуулиуд дахь Багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа хэрхэн явагддаг вэ ?

Энэхүү илтгэлийг аймгийн гурван сургуулиар явж багш хөгжлийн төвүүдийнх нь үйл ажиллагаатай танилцаж багш нараас судалгаа авч ажилласан. 1, 2-р сургуулийн хувьд багш хөгжлийн төвтэй харин 5-р сургуулийн хувьд ангийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалан багш хөгжлийн төвөө түр хугацаанд анги болгон ашиглаж байлаа.




2. Хоёрдугаар бүлэг - Судалгааны хэсэг

2.1 Ерөнхий боловсролын сургуулиудын багш хөгжлийн төвийн үйл

ЕБС-ийн багш нараас дараах судалгааг авч багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа хэрхэн үр дүнтэй явагдаж буй эсэх, багш хөгжих орчин бүрдсэн эсэх мөн багш хөгжлийн төвөөрөө дамжин багшийн хөгжиж буй байдал цаашид багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулж багшийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал зэргийг судлахыг зорилоо.

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Судалгаанд 3 сургуулийн нийт 45 багш хамрагдсан ба судалгаанд оролцогч багш нарын ажилласан жилийг авч үзвэл :



*1-5 жил ажилласан 15 багш

*6-10 жил 21 багш

*11-15 жил ажиллаж байгаа 18

*15-аас дээш жил ажиллаж байгаа 11

2.2 Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулсанаар багшийн хөгжилд гарах эерэг үзүүлэлтүүдийг судалсан судалгаа

Асуулт 1

Танай сургуулийн багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа хэрхэн явагддаг вэ?




Судалгаанаас харахад ЕБС-дад багш хөгжлийн төв байдагч энэ нь бүрэн утгаараа хэрэгждэггүй үйл ажиллагаа зорилго чиглэл, үр дүнг илүү сайжруулах шаардлагатай нь харагдаж байна

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Асуулт 2

Та сургуулийнхаа багш хөгжлийн төвөөрөө дамжин хөгжиж чадаж байна уу ?



Судалгаанаас харахад багш хөгжлийн төв нь багш нарын хөгжилд нөлөөлдөг нь харагдаж байгаа бөгөөд хөгжлийн төлөвлөгөө гарган ажиллавал илүү үр дүн гарах нь харагдаж байна.

Асуулт 3

Багш хөгжлийн төвтэй болсноор таны хөгжилд ямар үр дүн үзүүлсэн үзүүлсэн бэ?



Багш нар хамт хөгжих төвтэй байснаар хамт олонч зэрэг байдал бий болдог, цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, бусдаасаа суралцах түүнчлэн харилцан уялдаа холбоотой ажиллах орчин нөхцөл бүрддэг нь харагдаж байна.

Асуулт 4

Цаашид багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулахад таны санал

- Багш хөгжлийн төвийн таатай орчинг бүрдүүлэх /интернет, номын сан, цай, кофе уух / гэх мэт
- Хамтран хөгжих боломжоор хангах
- Хэрэгцээт сургалтуудыг зохион байгуулах
- Гадаад дотоодын бусад сургуулиудтай хамтран ажиллах

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

2.3 Жишиг багш хөгжлийн төв байгуулж өөрийн сургуулийн багш нараа ажлын байрандаа үр дүнтэй хөгжих боломжийг эрэлхийлсэн судалгаа

Өөрийн сургуулийн багш нарын ажлын байран дээрээ үр дүнтэй хөгжиж буй эсэхийг судлах, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд гарч буй саад бэрхшээлүүдийг тодруулах, багшийн бүхий л талаараа хөгжих хамгийн боломжтой нөхцлийг гаргаж ирэх, багш хөгжлийн төвөөр дамжин хөгжих боломжтой эсэх багш хөгжлийн төвийг байгуулсанаар ямар ямар эерэг үзүүлэлтүүд гарна гэж үзэж буйг судлах, багшийн хөгжлийн төв ямар орчин нөхцөлтэй хэрхэн ажиллавал илүү үр дүн гарч болохыг нээн илрүүлэхэд оршино.

Судалгаанд нийт 30 багш хамрагдсанаас 17 нь мэргэжлийн 13 нь ерөнхий эрдмийн багш нар байлаа.

Асуулт 1

Багш та ажлын байран дээрээ өөрийгөө бүхий л талаараа хангалттай хөгжүүлж чадаж байна уу?



Багш бидний хувьд ажлын байран дээрээ хааяа сургалтуудад хамрагддаг хэдий ч энэ нь хангалттай бус багш бидэнд шаардлагатай хэрэгцээт сургалтууд явагдах нь ховор байдаг учраас хөгжих нөхцлийг илүү сайжруулж өгөх нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Асуулт 2

Багшийн хөгжихөд тулгамдаж буй гол асуудлуудыг бичнэ үү.

- ✓ Хөгжих орчин бүрдээгүй
- ✓ Багшийн ажлын ачаалал их
- ✓ Багшийг хөгжүүлэх чиглэлийн ажил бага /сурган заах арга зүй, цахим хичээл боловсруулах программууд, шинэ мэдлэш мэдээлэл/
- ✓ Багшийг хөгжлөөр бус бичиг баримтаар дүгнэдэг
- ✓ Харилцан бие биенээсээ суралцдаггүй
- ✓ Туршлагатай багш нарын арга туршлагаас суралцдаггүй
- ✓ Цаг хомс
- ✓ Багшийн өөрийн хөгжих дэвших хандлага муу
- ✓ Сургалт семинарын чанар муу
- ✓ Багшийн заах арга, ур чадвар, мэдлэг дутмаг

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Асуулт 3


Багшийн бүхийл талаараа хөгжих хамгийн их боломжтой нөхцөл юу вэ



Энэ судалгаанаас үзэхэд багшийн хөгжих хамгийн чухал зүйл нь цогц орчин бөгөөд багш нар хамтдаа бүхий л талаараа хөгжиж болох таатай орчныг нэн тэргүүнд бий болгох үр дүнтэй хөгжих төлөвлөгөө боловсруулж ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Асуулт 4

Бид сургуульдаа багш хөгжлийн төвтэй болсноор ажлын байрандаа илүү үр дүнтэй хөгжинө гэж та үзэж байна уу?



Судалгаанаас харахад багш нарын маань 93% нь нэг өрөөнд сууж хамтдаа хөгжих, хамт олонч эерэг байдлыг бүрдүүлэх, бие биенээсээ суралцах хүсэлтэй байгаа нь харагдаж байна.

Жишигт багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Асуулт 5

Багш хөгжлийн төвтэй болсноор танд ямар ямар зэрэг үзүүлэлтүүд гарна гэж та үзэж байна вэ?

- ✓ Мэдлэг чадвараа дээшлүүлэх
- ✓ Харицан бие биенээсээ сурацах
- ✓ Үялдаа холбоотой хамтран ажиглах
- ✓ Цагийг үр бүтээлтэй өнгөрөөх
- ✓ Хамт олонч байдал сайжирна
- ✓ Шинэ мэдлэг мэдээллээр хангагдана

Асуулт 6

Багш хөгжлийн төв ямар байвал танд хөгжих боломж илүү байна гэж үзэж байна вэ?


- ✓ Интернет, техник хэрэгслээр хангагдсан тав тухтай орчин
- ✓ Тэргүүлэх болон заах арга багш нарынхаа тэргүүн туршлагыг судалдаг
- ✓ Багаар ажиглаж хамтдаа хөгжих таатай орчин
- ✓ Багш нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх
- ✓ Сурган, заах арга зүй, хууль, хэрэглээний програмууд, идэвхтэй сургалтын шинэ аргуудаар сургалт явуулдаг
- ✓ Хөгжих тусгай цагийн хуваарьтай
- ✓ Үр дүнд суурилсан бүтээлч
- ✓ Тодорхой зорилго чиглэлтэй сургуулийн онцлогийг авч үзсэн

Дүгнэлт

Багшийн ажиллаж буй орчин болох сургууль нь багш хөгжих мэргэжлийн орчин бөгөөд багшлах ажлын явцад тасралтгүй хөгжих нь сургууль багшийн хэрэгцээнд нийцсэн үр ашигтай хувилбар юм. Гэлцхүү бид хэрхэн яаж үр дүнтэй хөгжих вэ? гэдэг асуудал чухал. Багш нар хөгжих маш олон арга зам байгаагийн нэг нь сургуулийн багш хөгжлийн төв юм. Манай сургуулийн багш нарын хувьд нэгдсэн багш хөгжлийн төв байгуулж түүгээрээ дамжин жигд цогц байдлаар хөгжихийг илүүд үзэх болсон нь багш нарын нэгдсэн хэлэлцүүлгээс гарсан санал болон судалгаагаар харагдаж байна. Тиймээс багш бидний хувьд өөрсдийгөө хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх нь нэн чухал юм. Судалгаанаас болон гадаад дотоодын сургуулиудын туршлагаас харахад багш хөгжлийн төв нь багш нарын ажлын байрандаа үр дүнтэй хөгжихөд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг, хариццан бие биенээсээ суралцах, ажлын таатай орчин болж өгдөг нь харагдаж байна. Түүнчлэн БХТөөр дамжуулан багшийн хөгжихөд тулгамдаж буй олон асуудлыг шийдэх боломжтой хэмээн харж байна. Иймээс бид бүхэн багш хөгжлийн тухай хуулийн 7.1-р заалт⁴ болон 7.3-р⁵ заалтуудыг үндэслэн сургуулийн дотоод нөөц боломжоо ашиглан багш хөгжлийн төв байгуулах ажлыг даруй хийж сургуулийн багш нарын зөвлөлтэйгөө хамтран багшийн ажлын байранд нь үр дүнтэй хөгжүүлэх арга ажлыг цаг алдалгүй хийх шаардлагатай гэж үзэж байна. Багшийг хөгжүүлэх арга зам нь орчин бүрдүүлэлт, урам хайрлах, сургалт мэдээлэл, тасралтгүй шинэлэлт үйл ажиллагаа

Уул уурхайн салбарын жишиг сургуулийн хувьд багш бид жишиг байж бусдааа үлгэрлэхүйц хөгжсөн төлөвшсөн байх нь нэн тэргүүнийн асуудал юм.

Мэдлэгээ дээшлүүлэхэд мэргэжлийн төв болсөн өснө
Мэргэжл нэгтгэсээ ямагт сурдаг болтөө өснө
Эрхэлсэн ажлаараа үлгэрлэдэг бол тохой өснө
Эргэцүүлэн шүүж өөрийгөө ялдаг бол алд өснө



⁴ Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна.
⁵ Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хуртал хэмжээний зардлыг зарцуулна.

- Сургуулийн зүгээс багш хөгжлийн тухай хуулийн 7-р заалт мөн багш хөгжлийн хөтөлбөрийн 4.2.1 дэх заалтуудын хэрэгжилтийг хангаж мэрэгжлийн болон сургах зүй, хууль эрх зүйн ном хэвлэл, сургах бичиг, сургалтын хэрэгслэлдэхүүн бүхий номын сантай, багш нарын тэргүүн туршлага бүхий цахим мэдээллийн сан, заах арга зүй болон бусад мэдлэг чадвараа хөгжүүлэх таатай орчин бүхий жишиг багш хөгжлийн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх
- Сургуулийн удирдлагаас бараа ажлын байрандаа үр дүнтэй хөгжих орчин нөхцөлөөр хангаж өгөх
- Хөгжих цагийг тодорхой болгож дагаж мөрдүүлэх
- Багш нарын хөгжлийн ойрын , дундын , хэтийн төлөвлөгөөг багш хөгжлийн төвийн үйл ажиллагаатай уялдуулан хийх
- Сургуулийн багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах

Дэвшүүлэх санал

Жишиг багш хөгжлийн төв байгуулж багшийг ажлын байранд үр дүнтэй хөгжүүлэх нь

Ашигласан ном материал

1. Монгол улсын хөдөлмөрийн сайдын 2015 оны А/214 дүгээр тушаалаар
Мэргэлийн боловсрол сургалтын багшийн хөгжлийн хөтөлбөр
2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго
3. Монгол улсын уул уурхайн жишиг сургууль "Овьсүмбэр аймаг дахь
Политехник коллежийн 2018-2019 оны хичээлийн жилийн зорилго
4. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
5. www.google.com
6. www.tdc.edu.pk